

## Сэдэв: “НҮБ-ын шинэчлэл ба Монгол Улс”

проф. Д.Наранцэцэг /МУБИС/

Дэлхийн хоёрдугаар дайн дууссанаас хойш дэлхийн олон улсын харилцаанд асар их өөрчлөлтүүд гарах болсон нь НҮБ-ын үйл ажиллагааг шинэ нөхцөл байдалд дасан зохицохыг шаардах болсон. Нэн ялангуяа өнөөдрийн дэлхий ертөнц улам бүр глобалчлагдаж, олон улсын харилцаанд шинэ субъектууд тодорч /actors/, төрийн бус байгууллагуудын оролцоо нэмэгдэж, олон улсын эрх зүйн шинэ хэм хэмжээнүүд үүсч эхэлсэн нь хуучны тогтолцоо, зарчимтай зарим талаар зөрчилдөхөд хүргэж байна. Жишээ нь: дотоод хэрэгт үл оролцох зарчим нь хүмүүнлэгийн оролцоотой зөрчилдөж байхад “пенитенциар түэмгийлэл”, “превентив оролцоо” ба “ авторитар дэглэмүүдийн хууль бус байдал” зэрэг нь АНУ-ын гадаад бодлогын хүрээнд овжин ашиглагдаж буй нь улс үндэстнүүдийн тусгаар байдал ба хил хязгаарын халдашгүй байдлын зарчмыг зөрчсөөр байгаа болно. Үүнийг 1990-ээд оноос хойш өрнөсөн үйл явдлууд гэрчилнэ. /Косово,Ирак,Ливи,г.м./ Дэлхийн улс төрийн тогтолцоо ч шинэчлэгдэж, Вестфалийн загвараас улам бүр холдох боллоо.

НҮБ-ыг анх үүсгэн байгуулахдаа дэлхийн улс хоорондын зөрчлийг зохицуулах замаар даян дэлхийд энх тунх байдлыг сахин хамгаалах явдал байсан ч, өдгөө энэхүү форум нь глобал ертөнцийн бүрэлдэж буй шинэ улс төрийн тогтолцоонд дасан зохицох шаардлагатай болоод байна. НҮБ дахь хямрал нь 1990-ээд оны эхэнд энхийг сахиулах үйл ажиллагаатай шууд холбоотойгоор явагдсан.

XXI зуунд дэлхийн энх тайван ба аюулгүй байдал нь шинэ аюул заналхийлэлтэй учирч буй нь глобалчлалын сөрөг үр дагавар бөгөөд үүнийг анх НҮБ-ыг үүсгэж байхдаа харамсалтай нь бодолцоогүй юм. Өдгөө олон улсын терроризмаас аваад олон улсын төрөл бүрийн гэмт хэрэгтэй ганцаар тэмцэж, сөрөн зогсох хэдийнээ боломжгүй болжээ. Энэ утгаараа ч гэсэн НҮБ өдгөө хамгийн их үүрэг, итгэл хүлээсэн байгууллага болж, Дэлхийн Хамтын Нийгэмлэгийн хүрээнд дээрхи асуудлуудыг шийдвэрлэж чадах байгууллага болоод байна.

НҮБ-ын шинэчлэл, түүний өдгөө баримталж буй бодлого, стратеги зэрэг нь хэр зэрэг ач холбогдолтой буйг түүний гишүүн орнуудын идэвхжсэн үйл ажиллагаа, олон улсын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд эзэлж буй байр сууринаас харагдана. Иймд бид энэхүү илтгэлдээ НҮБ-ын шинэчлэлтийн асуудлыг өнөөгийн орчин үеийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага, их өөрчлөлтийн ерөнхий фон дээр авч үзэж, шинэтгэлийн үйл явцыг нэгтгэн дүгнэж, түүнд Монгол Улсын эзлэж буй байр суурь хэрхэн байгааг товч байдлаар тодорхойлох оролдлогыг хийлээ.

НҮБ-ын шинэчлэлт гэдэг нь – НҮБ-ын гол зохицуулах үүргийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн цогц арга хэмжээ бөгөөд орчин үеийн өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицох ба бүхий л чиглэлд түүний үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох бодлого мөн гэж

тодорхойлж болно. НҮБ-ын шинэчлэлт нь түүний бүтэц зохион байгуулалт, санхүү төсөв, боловсон хүчин, төрөлжсөн байгууллагууд болон АЗ-ийн тэлэлт, “1 субъект-1 дуу хоолой” зарчмыг хэрэгжүүлэх, вето эрхийг халах, энхийг сахиулах хүчний бодлого, бүхий л үйл ажиллагааны зорилго, зорилт зэргийг бүрэн хамрах замаар гишүүн орнуудын идэвхтэй оролцоог шаардаж, “Мянганы тунхаг”-ын хүрээнд дэлхий нийтийн өмнө тулгарсан асуудлуудыг хамтын хүчээр шийдвэрлэх үйл ажиллагаанд чиглэгдэж байгаа болно. НҮБ-ын шинэчлэлт нь Бутрос Гали, Кофи Аннан болон Пан Ги Мун зэрэг ерөнхий нарийн бичгийн дарга нарын сонгогдсон он жилүүд дэх үйл ажиллагаатай шууд хамааралтай. Эдгээрт:

НҮБ-ын шинэчлэлтийн гарааг **Бутрос Гали /1992-96, НҮБ-ын 6 дахь н/б/дарга/** ерөнхий нарийн бичгийн дарга болсноор эхлүүлсэн бөгөөд хэрэгцээ шаардлагыг түүний хэлсэн: “Олон үндэстнүүд хүчирхэг НҮБ ба илүү үр ашигтай, олон талт бодлогыг хүсэмжилж байна” үг нотлоно. Тэрээр НҮБ-ын бүтцийн шинэчлэлтийг хэрэгжүүлж, хоёр чухал баримт бичгийн баталсан нь: “Энхийн төлөөх хөтөлбөр” ба “Хөгжлийн тухай хөтөлбөр” байв. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнд НҮБ-ын бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлж, НҮБ-ын гишүүн орон бүрийг татвар төлөгч болгож чадсан.

**Кофи Аннан /1997-2006, НҮБ-ын 7 дахь н/б/дарга /** Тэрээр шинэчлэлтийн багц баримтыг боловсруулж танилцуулсан.”Глобал гэрээ”-г санаачлан түүний хүрээнд НҮБ-ын төсвийг бүрдүүлэх ажилд ТББ, хувь хүмүүс, доноруудын оролцоог нэмэгдүүлж чадсан. Менежментийн шинэчлэлтийг хэрэгжүүлж, үр ашиггүй зардлыг хумиж чадсан. Түүнчлэн “Мянганы чуулган”-ыг хуралдуулж тунхаг бичгийг баталж, түүнийг мөрдүүлэх тал дээр шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

2004 онд /Дээд түвшний бүлгийн хүрээнд боловсруулагдсан/ “Харьцангуй аюулгүй ертөнц” хэмээх илтгэлийг гаргаж, XXI зуун дахь хамтын аюулгүй байдлын асуудлыг цоо шинээр дүгнэн, НҮБ-ыг бэхжүүлэх тал дээр тодорхой алхмуудыг даруй хэрэгжүүлж, шинэ аюул заналхийлэл, дуудлагатай хэрхэн тэмцэхийг тодорхойлж өгсөн.

2005 оны 3-р сард “Илүү эрх чөлөөний үед: аюулгүй байдлын хөгжил ба бүхэнд хүний эрхийг олгоход” чиглэгдсэн энэхүү илтгэлдээ дээд түвшний бүлгийн үзэл санаанд тулгуурлан К.Аннан 2005 оны 9-р сард /A/res/60/I/ НҮБ-ын гишүүн орон бүрт НҮБ-ын тогтолцоог шинэчлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг санал болгосон.

2000 онд НҮБ нь энхийг сахиулах үйл ажиллагааны туршлагад дүн шинжилгээ хийх өргөн далайцтай төслийг хэрэгжүүлэх болж тус оны 3-р сард Лахдар Брахимаар удирдуулсан ажлын бүлгийг томилж, тогтолцооны бодит нөхцөл байдлыг авч үзсэний үндсэн дээр шинэчлэлтийг хэрэгжүүлэх тодорхой саналууд боловсруулах үүрэг даалгаврыг өгсөн байна. Шинжээчдийн ажлын үр дүнд “Брахимийн илтгэл” гэгч боловсруулагдан гарсан байдаг.Эдгээр нь шинэчлэлтийн хүрээнд 3 гол асуудлыг багцаар нь хөндөх саналыг оруулсан:

\* гишүүн-орнуудын өдгөө хүлээж буй үүргийг эргэн харах, шинэ үүргийг тодорхойлох;

\* бүтцийн өргөн далайцтай шинэчлэлтийг авч хэрэгжүүлэх;

\* санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх;

Түүнээс гадна илтгэлд мөн энхийг сахиулах үйл ажиллагааны зарчим, стратеги зэргийг эргэн харах, шинээр тодорхойлох шаардлагатай хэмээн үзсэн. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн НҮБ-ын гишүүн-орнууд дараах бичиг баримтуудад тусгалаа олсон үзэл баримтлалд тулгуурлан өргөн далайцтай шинэчлэлтийг хэрэгжүүлэх тал дээр санал нэгдэцгээсэн юм. Эдгээрт:

- “Ерөнхий номлол”/2008 он/ - энэхүү баримт бичиг нь НҮБ-ын энхийг сахиулагчдын байлдааны талбарын үйл ажиллагаанд оролцогчдод зориулсан практик зөвлөмж, үндсэн гол зарчмуудыг агуулна;
- Энхийн төлөөх операци-2010 /2006 он/ - Энхийг тогтоох операцийн хэлтсийн шинэчлэлтийн стратеги;
- 2005 оны Дэлхийн дээд хэмжээний уулзалтын үр дүнгийн баримт бичиг /A/RES/60/1/- энэхүү баримт бичгийн дагуу энхийг байгуулах Хороог үүсгэсэн;
- Аюул заналхийлэл, дуудлага ба өөрчлөлтийн талаархи Дээд түвшний хэсгийн илтгэл /A/59/565/- шинэ зуун дахь хамтын аюулгүй байдлын өргөтгөсөн үзэл баримтлал;

**Пан Ги Мун**- /2007 оноос өдгөө хүртэл, НҮБ-ын 8 дахь н/б/дарга / тэрээр НҮБ-ын үйл ажиллагааны талаар хэд хэдэн чухал шинэчлэлтүүдийг авч хэрэгжүүлсэн бөгөөд “Илүү сайхан дэлхийн төлөө, НҮБ-ыг хүчирхэг болгох” уриаг дэвшүүлсэн, дэлхийн хэт дулаарлын эсрэг бодитой арга хэмжээ авч ажиллаж, Дарфурын асуудлыг шийдвэрлэж улмаар Суданд энхийг сахиулах хүчнийг оруулж чадсан. 2010 оны 12-р сарын 16-нд НҮБ-ын үйл ажиллагааны шинэ чиглэлийг тодорхойлж, шинэчлэлтийг улам бүр гүнзгийрүүлэн ажиллаж байна.

НҮБ нь ийнхүү бүхий л чиглэлд маш идэвхтэй үйл ажиллагаа явуулж, шинэчлэлтийг гүнзгийрүүлж байгаа бөгөөд түүний нэгэн гишүүн-орны хувьд Монгол Улс ч мөн гар бие оролцож байна. Монгол Улс нь 1990-ээд оноос хойш:

- Гишүүнчлэлийн татвар төлөгч орон болсон.
- НҮБ-ын Хороодыг даргалж, бодитой үйл ажиллагааг хэрэгжүүлэх болсон.
- Энхийг сахиулах хүчинд өөрсдийн цэрэг дайчдыг илгээх болсон.
- АЗ-ийн тэлэлтийн хувилбаруудаар өөрийн байр суурийг илэрхийлэх болсон.
- НҮБ-ээс гаргаж буй баримт бичгүүд, Конвенцийн санаачлагч болсон.

## **Дүгнэлт:**

Монгол Улс нь 1994 онд гадаад бодлогын үзэл баримтлалаа боловсруулж олон тулгуурт нээлттэй бодлогыг хэрэгжүүлж байгаа билээ. 1961 онд НҮБ-д элсэж түүний бүрэн эрхт гишүүн болсноос хойш түүний салбар байгууллагуудын хүрээнд олон талт идэвхтэй үйл ажиллагаа явуулж, НҮБ-аас гаргасан олон зуун баримт бичигт нэгдэн, түүнийг санаачлах түвшинд ч ажиллаж өдгөө “Мянганы тунхаг-ын зорилтуудыг хэрэгжүүлэх болоод байна. Өнгөрсөн хугацаан дахь олон ололтын нэг нь Монгол Улс анх удаа энхийг хамгаалах хүчний талд бүрэн эрхт гишүүнийхээ үүргийг биелүүлж, дэлхийн халуун цэгт өөрсдийн цэрэг дайчдаа илгээж даян дэлхийн энх тунх байдлыг сахин хамгаалах үйлсэд жинтэй хувь нэмэр оруулах болсон. Цаашид Монгол Улс нь НҮБ-ын АЗ-ийн байнгын бус гишүүнээр сонгогдох, ажлын хэсгүүдийг удирдах, энхийг сахих үйл ажиллагаанд тогтвортой оролцох, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг тууштай хэрэгжүүлэхэд НҮБ-тай болон түүний гишүүн орнуудтай хамтран ажиллах зэрэг олон асуудлуудын талаар өөрийн байр суурийг улам бүр оновчтой тодорхойлох нь чухал болоод байна.

## **Ашигласан ном зүй:**

1. United Nations Resolution, A/RES/60/1/.
2. United Nations Millennium Declaration. (A/55/L.2). 8'th plenary meeting. Sept.20006
3. A new partnership agenda. Charting a New horizon for UN Peacekeeping. Executive summary. New York, July 2009.
4. A new partnership agenda. Charting a New horizon for UN Peacekeeping. Executive Summary. Annex II. New York, July 2009.